

14 хоногийн шуурхай мэдээ

2021.07.09

2021 оны 06 дугаар сарын 25-нд Суманд коронавирусын эерэг тохиолдол илэрсэнтэй холбогдуулан сумын онцгой комисс 2021 оны 06 дугаар сарын 25 нд хуралдаж А/66 тоот захирамжаар 06 дугаар сарын 25-ны 20⁰⁰ цагаас 06 дугаар сарын 28-ны 20⁰⁰ цаг хүртэл тэг зогсолтыг хийж тандалт судалгаа хийгдлээ. Тэг зогсолт хийсэнтэй холбогдуулан онцгой комиссын дарга Ө..Мөнх-Амгалан Говь-Угтаал АСА цогцолбороор ард иргэдэд мэдээлэл хийлээ .

2021 оны 06 дугаар сарын 28-ны өдөр А/67 тоот захирамжаар тэг зогсолтыг 07 дугаар сарын 01-ны 06⁰⁰ хүртэл сунгаж ойрын болон дам хавьталын тандалт судалгаа хийгдлээ.Тэг зогсолтын үед нийт 4 постонд 16 тээврийн хэрэгсэл 32 төрийн албан хаагч 24 цагаар ажилласан.2021 оны 06 дугаар сарын 30-ны А/69 тоот захирамжаар 0 зогсолтыг цуцалж өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллаж байна. 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд 2 пост 24 цагаар орсон гарсан тээврийн хэрэгсэл зорчигчийг бүртгэж 5 хүнсний дэлгүүр, 2 банктai хариуцлагын гэрээ байгуулж халдвар хамгаалалтын дэглэм, гэрийн хяналтанд байгаа иргэдэд хяналт тавьж ажиллаж байна.

Сум Дундын Эмнэлэг

Коронавирусын халдвар авсан иргэдээс 2 удаагийн давтамжаар 6 иргэнийг аймгийн нэгдсэн эмнэлэгт хүргэж өгөн эмчлүүлж байна. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд голомтонд байгаа 317 м2, бусад байгууллагын 86м2 нийт 403 м2 газарт ариутгал халдваргүйтэл хийлээ.

Улаанбаатар хотоос ирсэн болон ойрын хавьтлын 70 хүнд түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийж үүнээс эерэг 5 хүн, PCR оношлуураар 4 хүн нийт 9 иргэнээс коронавирусын эерэг тохиолдол гарлаа.

Хагас жилийн бараа материалын тооллогыг хийж тооллого хийсэн илтгэх хуудсаа сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Жаргалмаад өглөө. Гэрийн тусгаарлалтанд нийт 40 иргэн байна. 12-16 насны хүүхдүүдийг Коронавирусын вакцинд хамрууллаа

Ерөнхий боловсролын сургууль

Багш ажилчдын байрны аж ахуйн ажил, дээврийн засвар хийгдлээ. Сургуулийн удирдлага, нягтлан бодогч нар Аймгийн аудитын тайлангийн цахим хурал, болон Сангийн яамны цахим хуралд оролцлоо.

Хүүхдийн цэцэрлэг

Цэцэрлэгийн дээврийг жижүүр Мөнгөн-Өлзий, үйлчлэг Ц.Батцэцэг нар янзлаж нөхөөс хийлээ.

Нярав Э.Болормаа тогооч Т.Намсрай үйлчлэгч Ц.Батцэцэг тогооч М.Амарзаяа нар 7 хоногт 2 удаа байгууллагынхаа модыг услаж байна.

Тусгаарлах байранд тогооч Т.Намсрай, М.Амарзаяа, нярав Э.Болормаа, үйлчлэгч Ц.Батцэцэг нар иргэдэд хоол хийж байна.

07 дугаар сарын 01-нээс тогооч Т.Намсрай, М.Амарзаяа, нярав Э.Болормаа нар 24 цагийн эргүүл постонд ээлжлэн гарч байна.

Соёлын төв

“Өв их эрдэнэ” ардын билэг их авъяастан М.Буяндэлгэр агсны хэлсэн үг цэц билгийг алдаршуулах уралдааныг зарлаад байна.

“Ураг удам нутаг усныхаа тахилга шүтлэгт газруудаа эрхэмлэн дээдэлье” сэдэвт тэргүүн туршлагын улсын уралдаанд оролцохоор “Баян Уул” хайрханыхаа материалыг бэлтгээд байна.

Байгууллагын гадна талбайн зэрлэгийг зулгааж, модоо усаллаа.

ТАЙЛАН БИЧСЭН

АРХИВ,БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Г.АМАРБАЯР

ХЯНАСАН

ЗДТГАЗРЫН ДАРГА

Н.ӨЛЗИЙТОГТОХ